



**ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
VII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 06

Зуунмод

Иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын
хэмжээ, байршил, зориулалт тогтоох тухай

Аймгийн хэмжээнд 2022 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалт тогтоох тухай аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, уг асуудалд Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “З”, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Аймгийн хэмжээнд 2022 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, хэмжээ, байршлыг хавсралтаар дэмжиж, Монгол Улсын Засгийн газарт уламжлан батлуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоол, холбогдох бусад материалыг Засгийн газарт хүргүүлж, батлуулахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ЖАМБАЛСҮРЭН

0190013

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 7 дугаар
Хуралдааны 06-р тогтоолын хавсралт



АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2022 ОНД ИРГЭНД ӨМЧЛҮҮЛЭХ
ГАЗРЫН ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТЫН САНАЛ

Д/д	Сумдууд	Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх сумын төв, суурин газар\		Улсын чанартай авто зам дагуу өмчлүүлэх газар		Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа өмчлөх		Аж ахуйн зориулалтаар иргэнд үнээр нь өмчлүүлэх газар		Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнээр өмчлүүлэх газар		2022 оны өмчлүүлэх газрын хэмжээ	2022 онд газар өмчилж авах иргэдийн тоо
		газрын хэмжээ \га\	Иргэний тоо	газрын хэмжээ \га\	Иргэний тоо	газрын хэмжээ \га\	Иргэний тоо	газрын хэмжээ \га\	Иргэний тоо	газрын хэмжээ \га\	Иргэний тоо		
1	Алтанбулаг	1023.27	2221									1023.27	2221
2	Аргалант	83.26	268	7	100	2	15					92.26	383
3	Архуст	12.6	49									12.6	49
4	Батсүмбэр	30.43	160			0.46	1	0.1709	1			31.0609	162
5	Баян											0	0
6	Баяндэлгэр	11.69	65									11.69	65
7	Баянжаргалан	13.23	189									13.23	189
8	Баян-Өнжүүл	1.08	15									1.08	15
9	Баянхангай											0	0
10	Баянцагаан	2.8	40									2.8	40
11	Баянцогт	6.57	44									6.57	44
12	Баянчандмань	2.87	41	32.13	459							35	500
13	Борнуур	9.28	28			0.32	1					9.6	29
14	Бүрэн	4.69	40									4.69	40
15	Дэлгэрхаан	2.5	25									2.5	25
16	Жаргалант	74.18	467									74.18	467
17	Заамар	25.5	304									25.5	304
18	Зуунмод	4.49	89			43	808			0.7	40	48.19	937
19	Лүн	14.58	112									14.58	112
20	Мөнгөнморьт	34.5	115									34.5	115
21	Өндөрширээт	4.73	61									4.73	61
22	Сэргэлэн	29.73	117			0.2	3					29.93	120
23	Сүмбэр	9.5	95									9.5	95
24	Угтаал	1.92	12			6	26					7.92	38
25	Цээл	12.35	102			13.08	77					25.43	179
26	Эрдэнэ											0	0
27	Эрдэнэсант	4.5	50									4.5	50
Нийт дүн		1420.25	4709	39.13	559	65.06	931	0.1709	1	0.7	40	1525.311	6240